



АЖИЛТНУУДАД САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН НЭМЭГДЭЛ ХӨЛС ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Үйлдвэрлэлийн найдвартай, тасралтгүй үйл ажиллагааг ханган, эрчим хүч үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх, өртөг зардлыг бууруулан арвилан хэмнэлт гаргаж, төлөвлөгөөт зорилтыг биелүүлэн ажилласан ажилтнуудыг урамшуулах, хамт олны болон ажилтан бүрийн үүрэг хариуцлагыг сайжруулан, ажлын бүтээмжийг өсгөх, идэвхи санаачилгыг өрнүүлэн ажиллах, нэгжийн удирдлагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд уг журмын зорилго оршино.

1.2 Компанийн сарын ажлын эцсийн үр дүнгээр алба, хэлтэс, цехийн үр дүнгийн нэмэгдэл хөлсний хувь хэмжээг тогтоож, нэмэгдэл цалинг хуваарилна.

1.3 Сарын үр дүнгийн нэмэгдэл хөлсний дээд хэмжээ албан тушаалын болон тарифт цалингийн 50 хүртэл хувь байна.

Хоёр. Нэмэгдэл хөлсийг олгох хувийг тодорхойлох

2.1 Компанийн сарын ажлын үзүүлэлтийн биелэлтийг 2-р хавсралтын дагуу ХЦХ-ний эдийн засагч холбогдох мэргэжилтнүүдээр гаргуулж, сарын үр дүнг дүгнэх комиссоор хэлэлцүүлэн, тухайн сард компанийн хэмжээнд олгох нэмэгдэл хөлсний хувийг гаргаж, Гүйцэтгэх захирлаар батлуулна.

Үзүүлэлтүүд:

2.1.1 БҮТЭЭГДЭХҮҮН ТҮГЭЭЛТ - Цахилгаан эрчим хүч, Дулаан эрчим хүч

Тухайн сард биелээгүй бол тасарсан хувь хэмжээгээр хасаж тооцохдоо бүхэл хувьд шилжүүлж хасна.

2.1.2 АШИГ / АЛДАГДАЛ / Тухайн сарын ашиг алдагдлыг тасарсан хувь хэмжээгээр хасаж тооцохдоо бүхэл хувьд шилжүүлж хасна.

2.1.3 ДОТООД ХЭРЭГЦЭЭНИЙ ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ

Тухайн сарын биелээгүй хувь хэмжээгээр хасаж тооцохдоо бүхэл хувьд шилжүүлж хасна.

2.1.4 СПОТ-оор ХУДАЛДАН АВСАН ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ

Тухайн сард худалдан авсан болон худалдсан СПОТ-ын зөрүүг үндэслэн

- 0-20МВт-д -1%,

- 20МВт-аас дээш бол -2% хасаж тооцно.

2.1.5 ТЭЗҮ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН БЭЛЭН БАЙДАЛ

- Төлөвлөгөөт бус зогсолт гаргавал тохиолдол бүрд -1%

- Үндсэн тоноглолыг явуулж чадаагүй бол тохиолдол бүрд -1%

- Үндсэн тоноглолыг 72 цагаас дээш хугацаагаар явуулж чадаагүй бол тохиолдол бүрд 1-%

2.1.6 АВААРЬ, СААТАЛ, ОСОЛ

- Аваарь, саатал гарсан тохиолдол бүрд -1% хасаж тооцно.

- Осол гарсан тохиолдолд -7% хасаж тооцно.

2.1.7 ХАБЭА, ГАЛЫН ЗӨРЧИЛ, ХАБЭА-н ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

- Зааварчилгаа нарядын систем мөрдөөгүй бол

- ХАБЭА-н I, II, III -р шатны үзлэг зөрчил устгаагүй, үзлэг хийгээгүй.

- АЭД, ГЭД-д оролцоогүй, хийгээгүй тохиолдолд

- ХХ-ын хувцас, хамгаалах хэрэгслийг хэрэглээгүй бол

- Дээд газраас ирсэн албан бичгийн хариуг цагтаа өгөөгүй бол

- ХАБЭА-н өгсөн үүрэг даалгавар биелүүлээгүй

- Дээрхи зөрчлүүдийг гаргасан тохиолдолд 1-6% хүртэл хасч тооцно.

2.2 Цех, алба, хэлтсийн үр дүнгийн нэмэгдэл хөлсний хувийг тухайн нэгжийн үндсэн үйл ажиллагаатай уялдуулан баталсан үзүүлэлтийн дагуу тооцож, нэмэгдэл олгох дээд хувийг тогтоох ба энэ нь компанийн хэмжээнд тухайн сард олгохоор батлагдсан үндсэн хувиас хэтрэхгүй. Цех алба хэлтсүүд нь хамт олон дотроо хувь хүн тус бүрээр хэлэлцэн, нэмэгдлийн хувийг тодорхойлно.

Гурав. Үр дүнгийн нэмэгдэл цалингийн үзүүлэлтийг тооцох

3.1 Аваарь саатал гарсны улмаас компанид учруулсан хохирлын мөнгөн дүнгийн хэмжээнээс хамааруулан буруутай хувь хүн, хэсэг нэгж, цех хамт олонтой дараах байдлаар тооцно. Үүнд:

1. 10,000.0 мянган төгрөг хүртэл хохирол учруулсан бол хувь хүнтэй 100%, холбогдох албан тушаалтануудтай уг журмын 3.3 дахь заалтыг баримталж тооцох
2. 10,001.0-20,000.0 мянган төгрөг хүртэл хохирол учруулсан бол нэгж, хэсэгтэй 100 хүртэл хувь тооцох
3. 20,001.0-30,000.0 мянган төгрөг хүртэл хохирол учруулсан бол буруутай гэдэг нь тогтоогдсон цех, хэсэг, алба, хэлтэстэй 100 хүртэл хувь тооцох.
4. 30,001.0-40,000.0 мянган төгрөг хүртэл хохирол учруулсан, үйлдвэрлэлийн ослын акт бүртгэгдсэн тохиолдолд буруутай цех, хэсэг, алба, хэлтэстэй 100 хувь, нийт компаний хэмжээнд 50 хувь тооцох
5. 40,001.0 мянган төгрөгөөс дээш хохирол учирсан хүнд, ноцтой аваарь, саатал осол гарч, хүний амь нас эрсдсэн бол станцын хэмжээнд 100 хувь тооцох
6. Хэрэв хохирлыг буруутай этгээд бүрэн барагдуулсан бол дээрх заалтыг мөрдөхгүй.

3.2 Техникийн шалтгаанаар болон гадны байгууллагын буруугаас гарсан аваарь, саатлын үед сарын үр дүнгийн нэмэгдэл цалинг хасахгүй. Тухайн гадны компанид хохирлын төлбөрийг ногдуулах ба акт үйлдсэн байна. Хэрэв ноогдуулсан акт үйлдээгүй бол тухайн буруутай хүмүүс хариуцлага хүлээнэ.

3.3 Хүний буруутай үйл ажиллагаанаас гарсан аваарь, саатлын үед хэрвээ үүнд удирдлага зохион байгуулалтын үйл ажиллагааны дутагдал нөлөөлсөн гэж акт тогтоож, техникийн комиссийн дүгнэлт гарсан бол цехийн даргаас 5-10%, тухайн холбогдох инженерээс 10-20%, ээлжийн ажилчны буруутай үед ээлжийн даргаас 10-30%, ДИС-ээс 10-30% тус тус хасч тооцно.

3.4 Удирдлага зохион байгуулалтын үйл ажиллагааны дутагдал гэдэгт дараах ойлголтыг авч үзнэ. Үүнд:

- Дагалдан ажилтанг бие даан ажиллуулж тэр нь аваарь, саатал гаргасан.
- Ээлжийн зохицуулалт хийлгүй ажилтныг улираан ажиллуулсан.
- Техникийн арга хэмжээ авалгүй гэмтэлтэй болон ТАД, ААД-ийн зөрчилтэй бүрэн бус, бэлтгэлгүй тоноглол ажилд байлгасан, залгасан.
- Өмнө гарсан аваарь саатлын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө, ХАБЭА-н III шатны үзлэгийн төлөвлөгөө болон бусад үзлэгийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийгээгүй. Энэ нь аваарь, сааталд нөлөөлсөн.
- Тоноглол ба схемийн өөрчлөлтийн талаар наряд болон техникийн шийдвэр бичих буюу заавар дээр өөрчлөлт хийгээгүй, энэ нь аваарь, сааталд нөлөөлсөн.
- ХАБЭА-н эрсдэлийн мөрдөж ажиллаагүй, эргэлт шалгалт хяналтаар ажиллаагүй, цэвэрлэгээ үйлчилгээ хангалтгүй хийсэн.
- Нарядын системийн мөрдөлт хангалтгүй, ялангуяа наряд дутуу буюу буруу бичигдсэн, хариуцлагатай удирдагч, ажилд оруулагч нар үүргээ дутуу биелүүлсэн зэргээс ажлын байр бэлдэлт дутуу, сэлгэн залгалт алдаатай хийгдсэн.

- 3.5 Цех, алба, хэлтсийн сахилга бат муу, ажлын цагаар архи уусан, хулгай хийсэн, осол аваарь, саатал гарахад нөлөөлсөн бол алба, хэлтсийн дарга холбогдох албан тушаалтнуудын үр дүнгийн нэмэгдэл цалинг 50-100% хасна.
- 3.6 Сургалтын зардлаас санхүүжиж гадаад, дотоодын сургалт, тойрон аялал, туршлага судлах зэргээр явсан хүмүүсийн явсан хоногт нь ногдох үр дүнгийн нэмэгдэл цалинг олгоно.
- 3.7 Компанийг төлөөлөн улсын болон орон нутгийн чанартай уралдаан тэмцээн, бусад арга хэмжээнд оролцон ажлаасаа чөлөөлөгдсөн ажилтанд тухайн арга хэмжээнд амжилттай оролцсон, мөн зөрчил дутагдалгүй оролцсон зэргийг харгалзан нэмэгдэл цалинг олгоно. /Ажлаас чөлөөлөгдөн уралдаан тэмцээн, урлаг спортын арга хэмжээнд оролцсон ажилтны үр дүнг ЗУХ-ийн дарга, холбогдох цех, алба, хэлтсийн дарга нарын тодорхойлолтыг үндэслэн олгоно/
- 3.8 Шинээр ажилд орсон ажилтан /дагалдан/ нь ТАД, ААД-ын шалгалт өгч шалгалтанд тэнцсэн нь гүйцэтгэх захирлын тушаалаар баталгаажсан өдрөөс эхлэн нэмэгдэл цалинг олгох бөгөөд ТАД, ААД-ын шалгалт өгөх шаардлагагүй ажлын байрны ажилтан нь ХАБЭА, ГАУСД, эмнэлэгийн анхны тусламж, Хөдөлмөрийн тухай хуулийн мэдлэгийн шалгалт өгч, шалгалтанд тэнцсэн нь баталгаажсан өдрөөс эхлэн нэмэгдэл цалинг олгоно.
- 3.9 Ажилтан ТАД, ААД-ын ээлжит шалгалт мөн нэг цехээс нөгөө цехэд шилжих, цех дотроо ажлын байр өөрчлөгдөхөд ТАД, ААД-ын шалгалтыг программд заасан хугацаандаа өгөөгүй бол үр дүнгийн нэмэгдэл хөлс олгохгүй.
- 3.10 Цех, хэсэг, нэгжийн үйлдвэрлэлийн процесст ашиглагдаж буй тоног төхөөрөмж, машин, техникийн эд анги, сэлбэг хэрэгсэл хулгайд алдагдсан тохиолдолд хариуцаж буй цех, алба, хэлтсийн нэмэгдэл цалингийн хувиас хохирлын хэмжээг харгалзан 10%-иар хасаж тооцно.
- 3.11 I, II-р зэргийн саатал, аваарь, доголдол зөрчлийг тухайн сард бичигдэж байгаа актаар тооцож, спотын журам, сахилгын дүрэм, дотоод хэм хэмжээ, мазут тооцох журмуудыг үндэслэн тооцно.
- 3.12 Цаг бүртгэлийн журамд заасны дагуу сарын эцэст ЗУХ, ДХХ, Харуулын хэсэг, СЭЗХ-ээс гаргасан ажлын цаг ашиглалтын мэдээг үндэслэн, зөрчил гаргасан ажилтны сарын үр дүнгийн нэмэгдэл цалинг тохиолдол бүрд 1%, ажлаас хоцорсон эхний 10 минут тутамд 1%, 30-аас дээш минут хоцорсон үед 3% хасч тооцно.
- 3.13 Ажлын цаг ашиглалт муу, ажлаас хоцролт 5-аас дээш удаа, ажил тасалсан зөрчил 1 удаа гарвал удирдлага, цех, хэлтэс, албаны дарга, тухайн хэсгийг хариуцсан инженерүүдийн үр дүнгийн нэмэгдэл цалингаас 3% тооцож, хасалт хийнэ.
- 3.14 Сахилгын арга хэмжээ авагдсан ажилтны тухайн сарын үр дүнгийн нэмэгдэл цалинг 100% хасч тооцно. Арга хэмжээ авагдсан ажилтан ээлжийн амралт, өвчтэй, чөлөөтэй, бусад шалтгааны улмаас арга хэмжээ тооцох хугацаанд дутуу (тухайн сарын цагийн балансын 80%-д хүрээгүй) ажилласан бол нөхөж үр дүнг хасч тооцно. Үндсэн цалинг бууруулах арга хэмжээнд нэгэн адил хамаарна.
- 3.15 Спотоор ЦЭХ худалдах буюу худалдаж авсан тохиолдолд спотын журмыг мөрдөнө.
- 3.16 Ажилтан нь ХАБЭА хувцас бүрэн өмсөөгүй, цайны газарт бохир хувцастай орсон, тамхины тухай хууль зөрчсөн, ХАБЭА-3-шат, АЭД, ГЭД-ын ажлын гүйцэтгэл бүрэн бус, дээд газраас ирсэн хугацаатай хийгдэх ажлууд хугацаандаа хийгдээгүй, өгсөн үүргийн биелэлт хангалтгүй зэрэг зөрчил гаргасан тохиолдол бүрт 2% тооцож үр дүнгийн нэмэгдэл цалинг хасна. /Зөрчил гаргасан ажилтны нэрсийг тооцон, ХЦХ-ний эдийн засагчид өгнө/
- 3.17 Хөдөлмөрийн аюулгүй байдлын зөвлөл, ДХХ нь сар бүр станцын ажлын байрууд, ахуйн байр бүрээр үзлэг хийж, илэрсэн зөрчлийг дүгнэж, арилгуулах, сар бүрийн 10-нд дүнг нэгтгэж, илэрсэн зөрчлийг устгаагүй ХАБЭА-н хууль зөрчсөн тохиолдолд 2% хасаж тооцно.
- 3.18 Алба, хэлтэс, цехийн удирдлагууд, ерөнхий инженер нэмэгдэл цалингийн хувь хэмжээг гүйцэтгэх захирал тооцох бөгөөд удирдлагуудын ажлын хариуцлага, чанар, цаг ашиглалт, ажлын эцсийн үр дүнг дүгнэж, тухайн сарын нэмэгдлийн хувийг тооцно. Гүйцэтгэх захирлын үр дүнгийн нэмэгдэл хөлсийг тооцох үзүүлэлтийг ТУЗ баталж, холбогдох мэргэжилтнүүд гүйцэтгэлийг гарган, уг

биелэлтийн хувиар сарын үр дүнгийн нэмэгдэл хөлсийг олгоно. Тухайн сард компанийн хэмжээнд олгохоор тооцсон хувиар Гүйцэтгэх захирлын нэмэгдэл хөлсийг тооцно. Цех, алба, хэлтсийн дарга нарын нэмэгдэл цалингийн хувийг тооцохдоо удирдлагаас дүгнэсэн хувь, хариуцсан хамт олны нэмэгдлийн хувийг дундажлан авна.

Дөрөв. Эрх үүрэг

4.1 Цех, алба, хэлтсийн удирдлагууд өөрсдийн удирдлагад байдаг ажилтнуудын ажлыг дүгнэх нэмэгдэл хөлс олгох үзүүлэлтийг гаргаж, энэ журмын хавсралт болгон мөрдөнө.

4.2 Сарын үр дүн хэлэлцэх комисс нь цех, алба, хэлтсийн тоног төхөөрөмж, техник ашиглалт, горим барилт, ХАБЭА-н зөрчил, ТЭЗҮ-ийн биелэлт мөн тухайн хэсгийн ажилтны ажлын чанар, цаг ашиглалт, хариуцлагын үр дүнг дүгнэж, нэмэгдэл хөлсийг нэмэх, бууруулах эрхтэй.

4.3 Санхүү эдийн засгийн хэлтсээс санхүүгийн тайланг сар бүрийн 10-нд, улирлын болон жилийн эцсийн тайланг урьдчилсан байдлаар гаргана.

4.4 Үйлдвэрийн эдийн засагч орлого, үр дүнг, горим тооцооны инженер ТЭЗҮ-г төлөвлөгөөтэй харьцуулан эерэг, сөрөг нөлөөллийн шинжилгээг хийнэ.

4.5 ХАБЭА-н инженерүүд компанийн хэмжээнд галын зөрчил, ХАБЭАХ хэрэгжилтийг дүгнэж тайлан гаргана.

4.6 Хөдөлмөр цалин хөлсний эдийн засагч уг журмын хавсралт №2 дахь ҮР ДҮНГИЙН НЭМЭГДЭЛ ХӨЛС ОЛГОХ ХУВИЙГ ТОДОРХОЙЛОХ ҮЗҮҮЛЭЛТ, хавсралт №3-д дурдсан удирдлага, алба, хэлтэс, цехийн үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох үзүүлэлтийг хариуцсан албан тушаалтнуудаар дүгнүүлж бэлтгэсэн байна.

4.7 Захиргаа удирдлагын хэлтсээс сар бүрийн 10-нд сахилгын арга хэмжээ авагдсан ажилтнууд, тухайн сард жинхлээгүй ажилтнуудын үр дүнгийн хасагдах хувийг жагсаалтаар гаргаж, ХЦХ-ний эдийн засагчид өгнө.

4.8 Сар бүрийн 15-нд үр дүнгийн нэмэгдэл цалин хэлэлцэх комиссын хурлаар компанийн болон удирдлага, алба, хэлтэс, цехийн үзүүлэлтүүдийн биелэлтийг хэлэлцэж, тухайн сард олгох үр дүнгийн нэмэгдэл цалингийн хувийг батлагдсан маягтын дагуу тооцон, Гүйцэтгэх захирал батална.

4.9 ХЦХ-ний эдийн засагч нь тухайн сарын батлагдсан хувийн дагуу холбогдох тооцоог хийж, цех алба, хэлтсүүдэд олгогдсон үр дүнгийн нэмэгдэл цалингийн хувийг сар бүрийн 20-нд хуваарилна.

4.10 Цех, алба, хэлтсийн хариуцсан ИТА нар батлагдсан санд багтаан, ажилтануудад хуваарилсан үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох хувийг жагсаалтаар гарган, удирдлагаар батлуулан, ХЦХ-ний эдийн засагчаар хянуулж, сар бүрийн 22-нд цалингийн нягтлан бодогчид өгнө.

4.11 Тухайн ажилтантай хариуцлага тооцохдоо журмын ямар заалтыг үндэслэн үр дүнгийн нэмэгдэл цалин хассан шалтгааныг нэмэгдэл цалин ажилтануудад хуваарилсан жагсаалтын тайлбар хэсэгт тодорхой бичсэн байна.

4.12 Цех алба хэлтсийн удирдлага, ИТА нар ажиллагсдын үр дүнгийн нэмэгдэлийг батлагдсан сандаа багтаан, нэмэх бууруулах эрхтэй.

4.13 Хамтын гэрээний 1.11-р заалтыг үндэслэн ҮЭХ даргын сарын үр дүнгийн нэмэгдэл хөлсийг олгохдоо хийсэн ажлын тайланг үндэслэн, батлагдсан үзүүлэлт, станцын дундажаар тооцож, ажлын цагийн балансыг үндэслэн, нягтлан бодогчид бодож олгоно. ҮЭХ дарга, гэрээт галын байцаагч, гэрээт цайны газрын эрхлэгч нар нь тухайн сарын хийсэн ажлын тайланг үзүүлэлтийн дагуу бичиж, дараа сарын 10-ны дотор ХЦХ-ний эдийн засагчид өгсөн байна.

4.14 Нэмэгдэл цалингийн талаарх маргаантай асуудлыг ажилтан компанийн шат дараалсан удирдлагууд болон хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисст бичгээр ирүүлж шийдвэрлүүлнэ.

4.15 Үр дүнгийн нэмэгдэл цалингийн олгох хувь хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд журманд өөрчлөлт оруулах талаар гүйцэтгэх захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, ТУЗ-өөр батлуулж, мөрдөнө.

Тав. Хариуцлага

5.1. Ажилтны ажлыг буруу үнэлэн нэмэгдэл хөлсийг хасаж хохироосон, үндэслэлгүй нэмж тооцсон, баримт материалыг хугацаанд нь өгөөгүй, графикт хугацаанаас хоцроосон, цэвэр нямбай хөтлөөгүйгээс гарах хариуцлагыг буруутай ажилтан хүлээж, хохиролгүй болгоно.

5.2 Ажилтануудын ирцийг үнэн зөв бүртгэж, цалингүй чөлөө, өвчлөлтийн хоногийг цагийн баланст зөв тооцож оруулах, ажилд ирээгүй шалтгааныг бүрэн гүйцэд тодруулах, ажлын цагийг буруу оруулсан бол хариуцсан дарга, ИТА, санхүүгийн ажилтан, албан хаагч нарын сарын үр дүнгийн нэмэгдэл хөлсийг 5% -иар хасаж ,хариуцлага тооцно.



**“ЭДЦС” ТӨХК-ийн АЖИЛТНУУДАД
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОЛОН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГЭЭР
ЖИЛИЙН ҮР ДҮНГИЙН НЭМЭГДЭЛ ХӨЛСИЙГ ОЛГОХ ЖУРАМ**

НЭГ. Ерөнхий зүйл

Үйлдвэрлэлийн найдвартай ажиллагааг хангах, ажилтнуудын ажлын хариуцлагыг дээшлүүлэн, ажлын бүтээмжийг өсгөх, идэвхи санаачлагыг өрнүүлэх, ажлын эцсийн үр дүнд оруулсан хувь нэмэр, хүчин чармайлтыг үнэлж, урамшуулахад энэхүү журмын зорилго оршино.

ХОЁР. Жилийн үр дүнгийн нэмэгдэл хөлсийг тооцох хуваарлах

1. Жилийн үр дүн тооцох шалгуур үзүүлэлтийг ТУЗ-ийн хурлаас тогтоох бөгөөд биелэлтийг үндэслэн олгох нэмэгдэл хөлсний дээд хэмжээг ТУЗ-ийн хурлаар батална.
2. Эрчим хүчний салбарын 2021-2022 оны Хамтын хэлэлцээрийн 3.6-д заасны дагуу „Үйлдвэрлэлийн болон санхүүгийн үйл ажиллагааны үр дүнгээр жилийн үр дүнгийн нэмэгдэл хөлсийг олгох,, шалгуур үзүүлэлтийн биелэлтийг ТУЗ-ийн тогтоолоор баталсан хүснэгтээр дүгнэж тооцох ба жилийн үр дүнгийн нэмэгдэл хөлсийг албан тушаалын болон тарифт цалингийн жилийн дундажаас 3 хүртэлх сараар тооцож олгоно.
3. Алба, хэлтэс, цехийн хамт олны тайлан хамгаалалтаар авсан дүнгээр тухайн хамт олонд олгох нэмэгдэл хөлсний хувийг тооцно. Алба, хэлтэс, цехийн хамт олонд нэмэгдэл хөлсийг хүснэгт №1, 2-д заасан үзүүлэлтийн дагуу хуваарилна.
4. Тайлан хамгаалалтын дүнг доорх үзүүлэлтүүдийн дагуу тооцож, дүгнэнэ.
5. Тухайн ажилтны жилийн ажлын үр дүнг харгалзан 5 хүртэлх сарын үндсэн ба тарифт цалинтай тэнцэх хэмжээний жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлсийг тогтоосон санд багтаан олгож болно. Тайлан хамгаалалтын комиссын удирдамжийн дагуу тухайн жилд үр бүтээлтэй сайн ажилласан ажилтны хийсэн ажлын үр дүнгийн нэмэгдлийг нэмэгдүүлэх хүсэлт бүхий тодорхойлолтыг харъяа цех, алба, хэлтэс нь гаргаж өгнө.

**ЗУХ, ДХХ, СЭЗХ, ДБХ,ХААХ, Инженерийн албаны
нэмэгдэл хөлс тооцох үзүүлэлт**

Хүснэгт 1

№	Үзүүлэлт	ИА	СЭЗХ	ЗУХ	ХААХ	ДБХ	ДХХ
1	Станцын аваарь, саатал осолгүй ажиллагаа, аваарь саатлын судалгаа, акт тогтоосон байдал	15					
2	Станцын горим барилт ТЭЗҮ-ийн биелэлт	10					
3	Тоноглолын бэлэн байдал	10					
4	Их засвар, ТЗБАХ,ХО-ын хэрэгжилт	5			5		
5	Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, үр ашгийг дээшлүүлэх	5	15	10	10	10	10
6	Өр авлага барагдуулалт		15		5	30	10
7	Арвилан хэмнэлт,өртөг зардлын	10	10	5	5	5	10

	хэтрэлт, ШБАЗ						
8	Мэдээ тайлан тэнцлийг хугацаанд нь гаргасан эсэх	5	10	20	10	20	15
9	Материал сэлбэгийн хангалт, гадаад дотоод захиалгын гэрээлэлт, хэрэгжилт		5	5	15		5
10	ТАД, ААД, ГАУСД-ын хэрэгжилт, түүнд тавих хяналт /ХАБЭА/	5	5	5	5	5	15
11	Хууль дүрэм, бусад сурталчилгаа, сургалт, семинар, урлаг спортын ажлын чанар зохион байгуулалт	5	5	20	5	5	5
12	Хөдөлмөрийн сахилга, зөрчил, цаг ашиглалт	5	5	5	5	5	5
13	Бүтээмжийн талаар хийсэн ажлын биелэлт	5	5	10	5	5	5
14	Хагас бүтэн жилийн тооллого, чанар үр дүн	5	10		10		5
15	Үүрэг даалгаврын биелэлт /Бүтээлч даалгаврын биелэлт /	10	10	10	10	10	10
16	Станцын ахуйн болон ажлын байрны ариун цэвэр эрүүл ахуй, соёлжилтын талаархи ажил	5	5	10	10	5	5
	ДҮН	100	100	100	100	100	100

Станцын цехүүдийн нэмэгдэл хөлс тооцох үзүүлэлт

Хүснэгт 2

№	Үзүүлэлт	ТДЦ	Зуухан цех	Турбин цех	Цахилгаан цех	ДХХА	Хими цех	ДШС	МЦех
1	Аваарь осол сааталгүй ажиллагаа, судалгаа, акт	20	20	20	20	20	20	20	20
2	Станцын горим барилт ТЭЗҮ-ийн биелэлт	15	20	20	15	15	20	25	15
3	Тоноглолын бэлэн байдал	20	15	15	20	20	15	10	10
4	Их засвар, ТЗБАХ-ний ажлын хэрэгжилт, ШБАЗ	10	10	10	10	10	10	10	20
5	Хөдөлмөрийн сахилга, цаг ашиглалт, ТАД, ААД, ГАУСД-ийн хэрэгжилт	10	10	10	10	10	10	10	10
6	Өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, өртөг зардлын хэтрэлт, арвилан хэмнэлт	5	5	5	5	5	5	5	5
7	Бүтээмжийн талаар хийсэн ажлын биелэлт	5	5	5	5	5	5	5	5
8	Үүрэг даалгаврын биелэлт /Бүтээлч	10	10	10	10	10	10	10	10

	даалгаврын биелэлт/								
9	Ахуйн болон ажлын байрны ариун цэвэр, эрүүл ахуй, соёлжилтын талаарх ажлын биелэлт	5	5	5	5	5	5	5	5
	ДҮН	100	100	100	100	100	100	100	100

6. Нэмэгдэл хөлсний хувь хэмжээг тооцох үзүүлэлтүүдийг дүгнэх албан тушаалтнууд

Д/д	Үзүүлэлтүүд	Дүгнэх нэгж, хэсэг	Дүгнэх албан тушаалтанууд
1	Аваарь, саатал, осол, гэмтэл,ХАБЭА	ДХХ,ХАБЭА	ХАБЭА хариуцсан инженерүүд
2	Тоноглолын бэлэн байдал, станцын ТЭЗҮ, горим барилт, их засвар, ТЗБАХ-ийн хэрэгжилт	Инженерийн алба	ИА-ны дарга
3	Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, хөдөлмөрийн сахилга, хэв журмын зөрчил, цаг ашиглалт	ЗУХ, СЭЗХ	Хэлтсийн дарга нар
4	Өртөг зардлын хэтрэлт, хэмнэлт, мэдээ тайлан гаргалт, хугацаа	СЭЗХ, ДХХ, ДБХ	Хэлтсийн дарга нар
5	Нэмэгдэл хөлс авах эрх үүссэн эсэх, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажлын биелэлт	ЗУХ	Хэлтсийн дарга
6	Албан тушаалын болон тарифт цалингийн дундаж	СЭЗХ	ХЦХ-ний эдийн засагч, ХЦХ-ний нягтлан бодогч
7	Нийт ажилтнуудад олгох нэмэгдэл хөлс, хувиарлагдсан фонд	СЭЗХ	ХЦХ-ний эдийн засагч
8	Удирдлагын зүгээс тооцсон байдал	Удирдлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий инженер

Гурав. Нэмэгдэл хөлс олгохгүй буюу бууруулж олгох нөхцөл

1. Тухайн жилд ажлын цаг ашиглалт муу, ажлаас хоцрох, эрт явах, аваарь, саатал гэмтэл гаргасан, ажлын хариуцлага алдсан зэрэг шалтгаанаар нэг удаа арга хэмжээ авагдсан ажилтанд дараах хувиар бууруулан олгоно.

Үүнд:

- Аттестатчлал, удирдах байгууллагын мэргэжлийн шалгалтанд хангалтгүй дүн үзүүлсэн ИТА-ын үр дүнг -20%
 - Өөрийн буруутай, хууль зөрчсөн үйл ажиллагаанаас болж байгууллагад торгууль төлбөр, акт тавигдсан тохиолдолд буруутай ажилтнаас -20%
 - Нийт ажилтанд зарлах хэлбэрээр сануулах арга хэмжээ -10%
 - Нэг сар цалин бууруулсан бол -15%
 - Хоёр сар цалин бууруулсан бол -20%
 - Гурван сар цалин бууруулсан бол -30%
 - Хөдөлмөрийн болон технологийн зөрчил гарган давхар арга хэмжээ авагдсан бол -40%
 - Захиргааны санаачлагаар албан тушаал буурах хөдөлмөрийн сахилгын шийтгэлийн арга хэмжээ - 50%
2. Тухайн жилд захиргааны санаачлагаар болон өөрийн хүсэлтээр ажлаас халагдсан ажилтанд олгохгүй.
3. Шинээр ажилд орж тухайн жилд 6 сараас доош хугацаагаар ажилласан ажилтанд нэмэгдэл хөлс олгохгүй. /Жирэмсний амралтын чөлөө авсан болон чөлөөнөөс орсон, ажлын байр солих шаардлагатайн улмаас цалинтай чөлөөтэй байсан, өвчний улмаас чөлөө авсан, өндөр насны тэтгэвэрт гарсан, удирдах байгууллагын шийдвэрээр өөр газар шилжин ажилласан, томилолтоор шилжин ирж ажилласан хүмүүст үл хамаарна. / Дээрхи ажилтнуудад ажилласан хоногт ноогдохоор нь тооцон, нэмэгдэл хөлсийг олгоно.
4. Гүйцэтгэх захирал, ерөнхий инженер, СЭЗЭДЗ, ААЭДЗ, ҮЭХ-ны даргын жилийн үр дүнгийн нэмэгдэл хөлсийг компанийн дундажаар олгоно.

Хянасан: Гүйцэтгэх захирал
 Ерөнхий инженер
 ЭЗСЭОЗахирал
 СЭЗХ-ийн дарга
 ИА-ны дарга
 ЗУХ-ийн дарга
 Хуулийн зөвлөх
 ҮЭХ-ны дарга

Б.Бат-Эрдэнэ
 Б.Сурмаахорол
 С.Үнэнхүү
 Ч.Орхон
 П.Ганбат
 Х.Баттөр
 Л.Алтансүх
 П.Баттөр

Журамд өөрчлөлт оруулсан: ХЦХ-ний эдийн засагч

Л.Түмэнжаргал